

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Радио телевиз сүлжээний газар /УТҮГ/-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/05/НА-СТА-ТБОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Х.Еркебулан

Утас: 92921881 Цахим хаяг:erkebulankh@ audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
Байхгүй	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
РАДИО ТЕЛЕВИЗИЙН СҮЛЖЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА К.АРНАГУЛ ТАНАА

᠒᠐᠒᠑.᠐3.15 № 314
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Радио телевизийн сүлжээний газрын -Дүгнэлт

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Радио телевизийн сүлжээний газрын -Дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>21935525.11</u>	<u>24162287.65</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	301986.14	32508.69
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	301986.14	32508.69
3121	Төгрөг	301986.14	32508.69
31213	Арилжааны банк дахь харилцах	301986.14	32508.69
34	УРЬДЧИЛГАА	199000.00	199000.00
3471	Урьдчилгаа тооцоо	199000.00	199000.00
34714	Томилолтын урьдчилгаа	199000.00	199000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	21434538.97	23930778.96
354	Хангамжийн материал	21434538.97	23930778.96
35410	Бичиг хэргийн материал	318456.01	282156.00
35420	Аж ахуйн материал	4383503.00	3691943.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5628800.00	11366400.00
35440	Түлш, шатах тослох материал	1296.56	1296.56
35470	Бусад хангамжийн материал	11102483.40	8588983.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7373040101.59</u>	<u>7019417878.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7373040101.59	7019417878.16
392	Биет хөрөнгө	2421340101.59	2067717878.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	254253804.00	254253804.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22894501.98	-31364915.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147235934.20	258686934.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-65400584.66	-238921670.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4808512372.03	5075338752.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2707813671.30	-3257645464.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17467739.00	18827739.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10020989.70	-11457299.85
393	Биет бус хөрөнгө	4951700000.00	4951700000.00
39301	Програм хангамж	2270000.00	2270000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2270000.00	-2270000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4951700000.00	4951700000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7394975626.70</u>	<u>7043580165.81</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7394975626.70</u>	<u>7043580165.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7394975626.70	7043580165.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5135822546.00	5135822546.00
51101	Өмч: - төрийн	5135822546.00	5135822546.00
512	Хуримтлагдсан үр дүн	2200251356.59	1848855895.70
51210	Өмнөх үеийн үр дүн	2645776051.68	2200251356.59
51220	Тайлант үеийн үр дүн	-445524695.09	-351395460.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	58901724.11	58901724.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7394975626.70</u>	<u>7043580165.81</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	459,423,760.58	669,531,530.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,649,931.75	9,752,283.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,649,931.75	9,752,283.00
120002	Хүүгийн орлого	140,325.75	
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13,509,606.00	9,752,283.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,509,606.00	4,995,283.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	4,757,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	445,773,828.83	659,779,247.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	445,773,828.83	659,779,247.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	344,506,690.00	408,310,467.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	101,267,138.83	251,468,780.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	904,948,455.67	977,992,088.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	884,948,455.67	977,992,088.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	882,948,455.67	967,081,822.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,903,420.00	179,804,973.00
210101	Үндсэн цалин	193,903,420.00	179,804,973.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,647,426.00	24,143,908.80
210201	Тэтгэврийн даатгал	16,731,691.00	16,855,813.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,035,636.00	1,822,042.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,568,026.00	1,457,601.94
210204	Ажилгүйдлийн даатгал	392,005.00	364,400.47
210205	Эрүүл мэндийн даатгал	3,920,068.00	3,644,050.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,035,076.66	48,240,557.05
210301	Гэрэл, цахилгаан	27,224,918.66	27,948,181.05
210302	Түлш, халаалт	17,383,520.00	19,866,880.00
210303	Цэвэр, бохир ус	426,638.00	425,496.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,197,983.40	14,945,593.11
210401	Бичиг хэрэг	557,300.00	683,600.01
210402	Тээвэр, шатахуун	5,957,768.40	11,221,625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,566,737.00	1,497,808.10
210404	Ном, хэвлэл	165,000.00	137,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	951,178.00	1,405,560.00
2105	Нормативт зардал	802,100.00	10,014,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	802,100.00	10,014,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,471,970.00	64,454,475.00
210604	Урсгал засвар	27,471,970.00	64,454,475.00

2107	Томилолт, зочны зардал	8,102,400.00	4,511,000.00
210701	Гадаад албан томилолт	5,930,000.00	-
210702	Дотоод албан томилолт	2,172,400.00	4,511,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,090,650.23	46,488,114.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,210,758.93	7,946,319.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,867,891.30	20,907,279.50
210807	Газрын төлбөр	12,000.00	17,634,516.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	550,697,429.38	574,478,700.73
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	550,697,429.38	574,478,700.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	10,910,266.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	10,910,266.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	10,910,266.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,000,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	20,000,000.00	-
220001	Барилга байгууламж	20,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(445,524,695.09)	(308,460,558.19)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	42,934,902.70
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	42,934,902.70
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(42,934,902.70)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(445,524,695.09)	(351,395,460.89)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,135,822,546.00	58,901,724.11	2,200,251,356.59	7,394,975,626.70
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,135,822,546.00	58,901,724.11	2,200,251,356.59	7,394,975,626.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,135,822,546.00	58,901,724.11	2,200,251,356.59	7,394,975,626.70
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн				0.00

зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			-351,395,460.89	-351,395,460.89
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,135,822,546.00	58,901,724.11	1,848,855,895.70	7,043,580,165.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	358156621.75	413305750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13649931.75	4995283.00
120	Нийтлэг татварын бус орлого	13649931.75	4995283.00
120002	Хүүгийн орлого	140325.75	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13509606.00	4995283.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13509606.00	4995283.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	344506690.00	408310467.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	344506690.00	408310467.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	344506690.00	408310467.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	327445098.29	401252627.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327445098.29	401252627.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325445098.29	390342361.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195409674.00	179804973.00
210101	Үндсэн цалин	195409674.00	179804973.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23141172.00	24143908.80
210201	Тэтгэврийн даатгал	15225437.00	16855813.06
210202	Тэтгэмжийн даатгал	2035636.00	1822042.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	1568026.00	1457601.94
210204	Ажилгүйдлийн даатгал	392005.00	364400.47
210205	Эрүүл мэндийн даатгал	3920068.00	3644050.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45035076.66	48240557.05
210301	Гэрэл, цахилгаан	27224918.66	27948181.05
210302	Түлш, халаалт	17383520.00	19866880.00
210303	Цэвэр, бохир ус	426638.00	425496.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8616555.40	14237733.10
210401	Бичиг хэрэг	467300.00	647300.00
210402	Тээвэр, шатахуун	5957768.40	11221625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1566737.00	1497808.10

210404	Ном, хэвлэл	165000.00	157000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	459750.00	714000.00
2105	Нормативт зардал	619000.00	8875125.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	619000.00	8875125.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23499150.00	64007200.00
210604	Урсгал засвар	23499150.00	64007200.00
2107	Томилолт, зочны зардал	8102400.00	4511000.00
210701	Гадаад албан томилолт	5930000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2172400.00	4511000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21022070.23	46521864.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3142178.93	7980069.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17867891.30	20907279.50
210807	Газрын төлбөр	12000.00	17634516.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2000000.00	10910266.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2000000.00	10910266.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2000000.00	10910266.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30711523.46	12053122.55
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30573000.00	12322600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30573000.00	12322600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30573000.00	12322600.00
220001	Барилга байгууламж	20000000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10573000.00	12322600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-30573000.00	-12322600.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	138523.46	-269477.45
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	163462.68	301986.14
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	301986.14	32508.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		301986.14
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441061690.00	413305750.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441061690.00	413305750.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	429951490.00	402395484.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190096470.00	179804973.00
210101	Үндсэн цалин	190096470.00	179804973.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25663020.00	24143908.80
210201	Тэтгэврийн даатгал	18059157.00	16855813.06
210202	Тэтгэмжийн даатгал	1900974.00	1822042.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	1520766.00	1457601.94
210204	Ажилгүйдлийн даатгал	380207.00	364400.47
210205	Эрүүл мэндийн даатгал	3801916.00	3644050.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48050600.00	47971079.60
210301	Гэрэл, цахилгаан	27442000.00	27678703.60
210302	Түлш, халаалт	19867000.00	19866880.00
210303	Цэвэр, бохир ус	741600.00	425496.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18532000.00	14237733.10
210401	Бичиг хэрэг	650000.00	647300.00
210402	Тээвэр, шатахуун	15097000.00	11221625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1960000.00	1497808.10
210404	Ном, хэвлэл	150000.00	157000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	675000.00	714000.00
2105	Нормативт зардал	9051000.00	8875125.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9051000.00	8875125.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78592600.00	76329800.00
210604	Урсгал засвар	78592600.00	76329800.00
2107	Томилолт, зочны зардал	9200000.00	4511000.00
210702	Дотоод албан томилолт	9200000.00	4511000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50765800.00	46521864.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8000000.00	7980069.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24988800.00	20907279.50
210807	Газрын төлбөр	17777000.00	17634516.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11110200.00	10910266.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11110200.00	10910266.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11110200.00	10910266.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	441061690.00	413305750.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	427061690.00	408310467.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	427061690.00	408310467.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14000000.00	4995283.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14000000.00	4995283.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		301986.14
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		32508.69
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		18.00	18.00
620001	Удирдах ажилтан		2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан		13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан		3.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		18.0	18.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		18.00	18.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Радио телевиз сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Радио телевиз сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

- Баян-Өлгий аймгийн Радио телевиз сүлжээний газар нь Монгол улсын баруун бүсийн нутаг дэвсгэрт олон сувгийн радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг чанарын өндөр түвшинд дамжуулан хүргэх, сүлжээний техникийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, шинэ техник технологийг нэвтрүүлэн ард түмэнд мэдээ мэдээллээр үйлчлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус газарт 2021 онд дээд газраас дотоод аудитын шалгалт ирээгүй бусад эрх бүхий байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Радио телевиз сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 904.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 9.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажилагаа

Баян-Өлгий аймгийн Радио телевиз сүлжээний газар нь Монгол Улсын Баруун бүсийн нутаг дэвсгэрт олон сувгийн радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг чанарын өндөр түвшинд дамжуулан хүргэх, сүлжээний техникийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, шинэ техник технологийг нэвтрүүлэн ард түмэнд мэдээ мэдээллээр үйлчлэхэд оршино гэж тодорхойлжээ.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Радио телевиз сүлжээний газар нь 1965 онд байгуулагдсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Радио телевиз сүлжээний газар нь РТҮСГ-аас баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтөлж Сангийн сайдын 2006 оны 388

дугаар тушаалаар баталсан заавар аргачлалын дагуу “Acolous” программаар санхүүгийн тайланг гаргадаг байна.

Радио телевиз сүлжээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 351.3 сая төгрөгөөр буюу 4.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	302.0	32.5	-269.5
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	199.0	199.0	0.00
Бараа материал	21434.5	23930.8	2496.3
Үндсэн хөрөнгө	7373040.1	7019417.9	-353622.2
Нийт хөрөнгө	7394975.6	7043580.2	-351395.4
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7394975.6	7043580.2	-351395.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7394975.6	7043580.2	-351395.4

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхэнд 0.3 сая төгрөг ба онй эцэст 0.03 сая төгрөгөөр буурсан нь арилжааны банканд байгаа бэлэн мөнгөтэй холбоотой байна.

Урьдчилгааны үлдэгдэл 199.0 мянган төгрөг нь он дамжсан томилолтын урьдчилгаа байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 23.9 сая төгрөг болж 2.5 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 67.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй 4.7 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авч үйл ажиллагаандаа 69.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7019.4 төгрөг болж 3162.0 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 12.3 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 251.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй авч, 199.5 сая төгрөгийн хөрөнгийг Радио телевизийн үндэсний сүлжээний газраас балансаас баланст шилжүүлэн авч, 83.5 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 574.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 7043.6 сая төгрөг болж 351.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 351.4 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 669.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 210.1 сая төгрөгөөр буюу 50.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 73.0 сая төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, норматив зардал, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал

шилжүүлэг зэрэг зардлууд байна. Цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл, томилолт зочны зардлууд өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Радио телевиз сүлжээний газрын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 441.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 441.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Радио телевизийн Үндэсний Сүлжээ Улсын Төсөвт Үйлдвэрийн газраас тус газрын 2021 оны үйл ажиллагааны төсвийг 441.1 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 427.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 14.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд 441.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 413.3 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 27.8 сая төгрөгийн бага зардал гаргасан байна.

Улсын төсвөөс 427.0 сая төгрөгийн санхүүжилт авахаас 408.7 сая төгрөгийн санхүүжилт авч 18.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдожээ.

Туслах үйл ажиллагааны орлогоос 14.0 сая төгрөгийн орлого оруулахаас 5.0 сая төгрөгийн орлого оруулж орлогын төлөвлөгөө 9.0 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Ковид-19 цар тахлын үед орон нутгийн телевизийн нэвтрүүлгийг үнэ төлбөргүй дамжуулсантай холбоотой тасарсан байна.

Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, түлш халаалт, цэвэр бохир ус, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, интернэтийн төлбөр, нормын хувцас, зөөлөн эдлэл, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зэрэг зардлуудыг хэмнэж ажилласан байна. Ковид-19 цар тахлын улмаас танаж болох бүх зардлуудыг хэмнэж ажилласан байна.

Нийт төсвийн 43.5 хувийг цалин, 5.8 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 11.6 хувийг тогтмол зардал, 3.4 хувийг хангамж бараа материалын зардал, 2.1 хувийг норматив зардал, 18.5 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 1.1 хувийг томилолт, зочны зардал, 11.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 2.7 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Радио телевиз сүлжээний газар 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Радио телевиз сүлжээний газар нь 2021 онд нийт 413.3 сая төгрөгийн 91 мэдээллийг ил тод байршуулахаас 70 мэдээллийг хугацаандаа байршуулж, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй 45.2 сая төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй, 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 77.0 хувьтай, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд аудитаар шилэн данстай холбоотой 7.5 сая төгрөгийн зөрчилд 1 заалттай зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийн биелэлтийг Радио телевиз сүлжээний газрын 2021.06.11-ний 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг шалгаж үзэхэд өмнөх онд гарсан зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 45.2 сая төгрөгийн зөрчил илэрч 45.2 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 45.2 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1. Радио телевиз сүлжээний газар нь 2021 онд шилэнд дансанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй 45.2 сая төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй, 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 77.0 хувьтай, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн оруулах, зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Радио телевиз сүлжээний газар										
Дүн											

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Радио телевиз сүлжээний газар	1	45.2					1	45.2		
Дүн		1	45.2					1	45.2		
Нийт дүн		1	45.2					1	45.2		